

1. 2006 онд эртний хүний чулуужсан гавлын үлдэгдэл Монголоос олдсон. Эхний шатны судалгаагаар уг гавал неандерталь хүн, хомо эректус, эртний хомо сапьянсын шинжүүд агуулж буйг тогтоосон байна. Өвөг түүхийн үеийн энэ хүний гавлын ясны үлдэгдэл Монгол орны аль аймаг сумын нутгаас олдсон бэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/
 - a. Сэлэнгэ аймгийн Шаамар сум Шаамар
 - b. Баян-Өлгий аймгийн Цэнгэл сум Могойтын хавцал
 - c. **Хэнтий аймгийн Норовлин сум Салхит**
 - d. Хэнтий аймгийн Баян-Адарга сум Дуурлиг нарс
2. Энэ дурсгал нь дөрвөлжин буюу дугуй хүрээ чулуутай, голдоо дугуй чулуун овоолго дараас бүхий байгууламж бөгөөд Монгол болон хөрш зэргэлдээ Алтайн бүс, Шинжааны хязгаар, Байгал нуур хавиас олддог. Энэ Хүрлийн үед хамаарах ямар дурсгалыг тодорхойлсон бэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/
 - a. Буган хөшөө
 - b. Дөрвөлжин булш
 - c. **Хиргисүүр**
 - d. Түүвэр олдвор
3. Адууг уналга тээвэрт ашиглах болсон явдал нүүдлийн мал аж ахуй үүсэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн. Археологийн баримтаар Монгол нутагт адууг хамгийн анх хэдий үед гаршуулсан бэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/
 - a. **НТӨ 1300-1400 он**
 - b. НТӨ 1500-1600 он
 - c. НТӨ 1700-1800 он
 - d. НТӨ 1900-2000 он
4. 2025 онд Хүннү гүрэн байгуулагдсаны хэдэн жилийн ой тохиож байгаа вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/
 - a. 2233
 - b. **2234**
 - c. 2235
 - d. 2236
5. Ховд аймгийн Мянгад сумын нутаг Урд улаан үнээт уулнаас олдсон эмээл нь дэлхийн хамгийн эрт үед холбогдох зүймэл модон эмээлийн олдвор болсон. Тус эмээл он цагийн хувьд аль үед хамаарах олдвор вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/
 - a. Хүннү гүрний үед
 - b. **Сяньби улсын төгсгөл, Жужан улсын эхэн үед**
 - c. Жужан улсын сүүл үе
 - d. Түрэг улсын үед
6. Монголын Цагаадай улсыг үндэслэгч хэн бэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/
 - a. Тэмүүжин, Бөртэ нарын ууган хүү
 - b. **Тэмүүжин, Бөртэ нарын хоёрдугаар хүү**
 - c. Тэмүүжин, Бөртэ нарын гутгаар хүү

- d. Тэмүүжин, Бөртэ нарын отгон хүү
7. Монголын эзэнт гүрний нийслэл Хархорум хот ямар шалтгааны улмаас сүйдсэн бэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/
- a. **Мин улсын довтолгооны улмаас**
 - b. Хаан ширээний төлөөх тэмцлийн дүнд
 - c. Бүгд зөв
 - d. Бүгд буруу
8. XV-XVII зууны Монголд улс төрийн хямрал болоход нөлөөлсөн гол шалтгаан юу вэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/
- a. Хятадын Мин улсын явуулга, довтолгоон
 - b. Манжийн Тэнгэр тэтгэгч хааны явуулга, довтолгоон
 - c. **Хааны сүр хүч суларч, ноёдын биеэ даасан байдал бэхэжсэн**
 - d. “Хар тахал” гэж алдаршсан тахлаас болж эдийн засаг, нийгмийн тогтворгүй байдал үүссэн
 - e. Бурхны шашны зэн урсгал Монголд хүчтэй дэлгэрсэн
9. 1189 онд хаана Тэмүжинг Чингис хэмээн нэрийдэж, Монголын эзэн хан болгосон бэ?
- a. Хөх зүрхний хар нуур
 - b. Хэрлэнгийн хөдөө арал
 - c. **Хар зүрхний Хөх нуур**
 - d. Хорхунаг Жибурын хөндий
10. 1246 онд Гүюг хаанаас Ромын Иннокент IV папыг дагаар орохыг шаардаж илгээсэн перс хэлээр бичсэн захидлыг хэн гэдэг илчээр хүргүүлсэн бэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/
- a. Виллиам Де Рубрук
 - b. **Плано Карпини**
 - c. Марко Поло
 - d. Вильгельм Буш
11. Монгол Улс албан ёсоор хэдэн онд крилл үсэг хэрэглэж эхэлсэн бэ? Зөв хариултыг тэмдэглэнэ үү. /1 оноо/
- a. 1944
 - b. 1945
 - c. **1946**
 - d. 1947
12. 1913 онд Монголын төр Өвөрмонголын нутгийг чөлөөлөхөөр хэдэн замаар цэрэг хөдөлгөсөн бэ?
- a. 2 зам
 - b. 3 зам
 - c. 4 зам
 - d. **5 зам**
13. Шинэ эргэлтийн бодлого хэрэгжсэнээр дараах арга хэмжээнээс алийг нь хэрэгжүүлсэн бэ?
- a. Эдийн засгийн хямралыг гэтэлгэх, үйлдвэрлэх хүчийг нэмэгдүүлсэн
 - b. Малчдын мал маллах сонирхолыг дахин сэргээж, малын тоо толгойг өсгөсөн,

- c. Үндэсний аж үйлдвэрийг байгуулсан,
 - d. Бүгд зөв**
 - e. Бүгд буруу
14. Гадаад Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх тухай Монголын бүх ард түмний санал хураалт хэдэн онд болсон бэ?
- a. 1943 он
 - b. 1944 он
 - c. 1945 он**
 - d. 1946 он
15. Атрын хоёр дахь аян хэдэн онд эхэлсэн бэ?
- a. 1974 он
 - b. 1975 он
 - c. 1976 он**
 - d. 1977 он
16. . Монгол улсаас Дэлхийн соёлын өвд бүртгэгдээгүй дурсгал аль нь вэ?
- a. Орхоны хөндий
 - b. Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор
 - c. Бурхан Халдун уул түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг
 - d. Увс нуурын ай сав газар**
17. Чингис хаан ямар шашин шүтлэгтэй байсан бэ?
- a. Бөө мөргөл
 - b. Буддын шашин
 - c. Тэнгэр шүтлэг**
 - d. Бомбын шашин
18. Сансрын хүрд /орчлонгийн хүрд/-ний төв хэсэгт байдаг 3 амьтныг нэрлэнэ үү.
- a. Луу, бар, заан
 - b. Туулай, шувуу, сармагчин
 - c. Тахиа, могой, гахай**
 - d. Хангарди, арслан, бар
19. Бурханы шашны уламжлалуудаас Монголд хамгийн өргөн дэлгэрсэн нь аль вэ?
- a. Теравада буюу бага хөлгөн
 - b. Махаяна буюу их хөлгөн**
 - c. Зэн буддизм
 - d. Бүгд жигд тархсан байдаг
20. IV Далай лам Ёндонжамц Лигдэн хааны үед Монголын шашин, улс төрийн амьдралд нөлөө бүхий хүн байсан. IV Далай лам Ёндонжамцтай холбоотой зөв мэдээллийг сонгоно уу?
- a. IV Далай лам Ёндонжамц Монголд шарын шашныг дэлгэрүүлэхэд хамгийн их хүчин зүтгэл гаргасан.
 - b. IV Далай лам Ёндонжамц монгол хүн байсан.
 - c. Ёндонжамц 1603 онд Төвдийн нийслэл Лхаст орчиж Далай ламд өргөмжлөгдсөн.

d. Бүгд зөв

21. Монгол цутгуурын урлаг буюу цул цутгуурын өвөрмөц аргыг нээж, Их хүрээний гол шүтээн Очирдарь, Майдар бурхад, Цагаан зандангаар бүтээсэн Жанрайсаг тэргүүтэй язгуурын таван бурхан, Бурхны найман мөнгөн суварга, Эрдэнэ зуу дахь Очирдара бурхан зэргийг бүтээсэн урлаачийн нэр хэн бэ?
- a. Бурханч лам Пүрэвбат
 - b. Хүрээний нэрт урч Омбо
 - c. **Өндөр Гэгээн Занабазар**
 - d. Зая Бандида Намхайжамц
22. Эртний түүх соёлт энэтхэг, ланз, нагар үсгээс санаа авч Өндөр Гэгээн Занабазар 1686 онд Соёмбо үсгийг зохиосон. Соёмбо цагаан толгой хэдэн үсэгтэй вэ?
- a. 80
 - b. 85
 - c. **90**
 - d. 95
23. Лигдэн хааны үед Монголын 35 хэлмэрч Гунгаа-Одсэрийн удирдлагаар буддын шашны нэгэн судрыг орчуулах ажлыг 1628-1629 онд бүр мөсөн дуусгаж, эмхэтгэн гаргасан. Энэ судрын нэр юу вэ?
- a. **Ганжуур их хөлгөн судар**
 - b. Данжуур их хөлгөн судар
 - c. Хутагт эрдэнэ гарахын орон нэрт их хөлгөн судар
 - d. Хутагт дээд Алтангэрэл судар
24. I-X дугаар Богд хүртэл хэд нь Монгол хүн бэ?
- a. 2
 - b. **3**
 - c. 4
 - d. 5
25. Үндэсний их баяр наадмаар Халх сурын харваанд эрэгтэй, эмэгтэй харваачид хэдэн метрийн зайнаас харвадаг вэ?
- a. Эрэгтэй 55 метр, эмэгтэй 45 метр
 - b. Эрэгтэй 65 метр, эмэгтэй 55 метр
 - c. **Эрэгтэй 75 метр, эмэгтэй 65 метр**
 - d. Эрэгтэй 85 метр, эмэгтэй 75 метр
26. Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад бүртгэгдээгүй өвийг нэрлэнэ үү?
- a. Монгол ардын уртын дуу
 - b. **Мал маллах уламжлалт арга ухаан**
 - c. Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг
 - d. Монгол шагайн харваа
27. Ард түмний соёлын түвшинг дээшлүүлэх, ялангуяа ахуйд соёл нэвтрүүлэхэд 1959-1961 онд зохион байгуулсан соёлын довтолгоон хэмээх компанит ажил чухал үүрэг гүйцэтгэсэн. Соёлын довтолгооны компанит ажилд хамаарахгүй зүйл нь аль вэ?
- a. Хүн бүр оо, саван, сойз хэрэглэж сурч, хот суурин газар бүсгүйчүүл үнэртэй ус, энгэсэг түрхэж сурсан.
 - b. **Хоол хүнс, махаа зориулалтын газар бэлтгэдэг болсон.**

- c. Хот суурин газар долоо хоног бүр халуун усанд орох болсон.
 - d. Навсархай шар эсгий гэрүүдийг цагаан бүрээсээр бүрж, ихэнх айл гэрийг дотуур хөшигтэй болгосон.
28. Амьтан ургамлын үлдвэр үлдэх боломжтой чулуулаг аль нь вэ?
- a. Бялхмал чулуулаг
 - b. Боржин чулуулаг
 - c. Метаморф
 - d. **Бүгд буруу**
29. Хянганы нурууны дийлэнх хэсэг нь аль улсын нутагт хамаарах вэ?
- a. Монгол улс
 - b. ОХУ
 - c. **БНХАУ**
 - d. БНАСАУ
30. Архангай аймгийн их тамир суманд байрлах Тайхар чулуу нь ямар төрлийн чулуулагт хамаарах вэ?
- a. Тунамал чулуулаг
 - b. Бялхмал чулуулаг
 - c. **Боржин чулуулаг**
 - d. Бүгд буруу
31. Дараах унтарсан галт уулнуудаас хамгийн залуу нь аль нь вэ?
- a. Уран тогоо
 - b. **Хоргын тогоо**
 - c. Шилийн богд уул
 - d. Алтан овоо уул
32. Өмнөговь аймгийн “шар цав” хэмээх газар юугаараа алдартай вэ?
- a. Үлэг гүрвэлийн өндөг ихээр олддог
 - b. Үлэг гүрвэлийн яс ихээр олддог
 - c. **Үлэг гүрвэлийн мөр хамгийн олон олддог**
 - d. Жуулчид ихээр үзэж сонирхдог
33. Үлэг гүрвэл ойролцоогоор хэдэн жилийн өмнө устаж үгүй болсон бэ?
- a. **60-65 сая жилийн өмнө**
 - b. 70-75 сая жилийн өмнө
 - c. 80-85 сая жилийн өмнө
 - d. Бүгд буруу
34. Үлэг гүрвэлийн хамгийн олон төрөл зүйлийн олдвор олдсон улс аль нь вэ?
- a. Монгол улс
 - b. АНУ
 - c. Аргентин улс
 - d. **БНХАУ**
35. Ховд гол нь аль ай савд хамаарах вэ?
- a. Хойд мөсөн далайн ай сав
 - b. Номхон далайн ай сав
 - c. **Төв азийн гадагш урсгалгүй ай сав**
 - d. Энэтхэгийн далайн ай сав
36. Хөвсгөл нуур ямар нөлөөгөөр үүссэн бэ?
- a. **Тектоник нөлөөгөөр**

- b. Галт уулын нөлөөгөөр
 - c. Хүндийн хүчний нөлөөгөөр
 - d. Мөсөн голын нөлөөгөөр
37. Нутгийн иргэд “Ургадаг нүүрс” хэмээн нэрлэдэг ургамлын нэрийг сонгоно уу.
- a. Таана
 - b. Заг**
 - c. Хайлаас
 - d. Гацуур
38. Тарвагатайн нуруу аль уулсын системд хамаарах вэ?
- a. Алтайн нуруу
 - b. Говь алтайн нуруу
 - c. Хэнтий нуруу
 - d. Хангайн нуруу**
39. Төв азийн их даралтын төв хаана үүсдэг вэ?
- a. Завхан аймгийн тосонцэнгэл
 - b. Хөвсгөл аймгийн баянзүрх
 - c. Архангай аймгийн хайрхан
 - d. Увс аймгийн улаангом**
40. Монгол орны аль хэсэгт илүү их салхилдаг вэ?
- a. Хойд хэсэгт
 - b. Урд хэсэгт**
 - c. Зүүн хэсэгт
 - d. Баруун хэсэгт
41. Дараах амьтдаас аль нь улаан номд багтсан бэ?
- a. Цоохор ирвэс
 - b. Голын халиу
 - c. Цэн тогоруу
 - d. Бүгд зөв**
42. Аялал жуулчлалын тухай хуулийн 10.1-д заасан жуулчны хөтөч-тайлбарлагчид үнэмлэх олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон мэргэжлийн ур чадварын зэрэглэл тогтоох журмыг хэн батлах вэ?
- a. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.**
 - b. Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо батална
 - c. Мэргэжлийн Хөтөч Тайлбарлагчдын Холбоо батална
 - d. Монгол улсын ерөнхий сайд батална
43. Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулга хэдэн онд Монгол Улсын Их Хурлаар батлагдсан бэ?
- a. 2019 он
 - b. 2020 он
 - c. 2023 он**
 - d. 2024 он
44. Дараах материалуудаас аль нь жуулчны хөтөч тайлбарлагчийн үнэмлэх авах, ангилал, зэрэглэл тогтоолгох хүсэлтэд багтахгүй вэ?

- a. Иргэний үнэмлэх
 - b. Өнгөт гэрэл зураг 2 хувь
 - c. **Ажил олгогчийн тодорхойлолт**
 - d. Аяллын хөтөч тайлбарлагчийн мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамрагдсан гэрчилгээ
45. Жуулчны хөтөч тайлбарлагчид үнэмлэх олгох, ангилал, зэрэглэл тогтоох журамд заасны дагуу нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь шалгалт дууссанаас хойш хэд хоногийн дотор шалгалтын дүнг нийтэд нээлттэй мэдээлж, нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн цахим хуудсанд байршуулах үүрэгтэй вэ?
- a. 3 хоног
 - b. 7 хоног
 - c. 10 хоног
 - d. **14 хоног**
46. Нийтийн эрх зүйн хуулийн этгээд шалгалт дууссанаас хойш хэд хоногийн дотор уг шалгалтад тэнцсэн иргэнд Жуулчны хөтөч-тайлбарлагчийн үнэмлэх, энгэрийн тэмдгийг олгох үүрэгтэй вэ?
- a. 14 хоног
 - b. 21 хоног
 - c. 28 хоног
 - d. **30 хоног**
47. Монгол улсын их хурлаар засгийн газрыг огцруулбал хэд хоногийн дотор дараагийн засгийн газрыг томилох хуультай вэ?
- a. 14 хоног
 - b. 21 хоног
 - c. 28 хоног
 - d. **30 хоног**
48. 2024 оны байдлаар Улаанбаатар хотын хүн амын тоо хэд байгаа вэ?
- a. 1.4 сая
 - b. 1.5 сая
 - c. 1.6 сая
 - d. **1.7 сая**
49. 2025 оны 9 сарын байдлаар Монгол улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин хэдэн хувьтай байгаа вэ?
- a. 10%
 - b. 7%
 - c. **5.5%**
 - d. 6.5%
50. Монгол улсын үндсэн хуулиар хэдэн нас хүрсэн монгол улсын иргэн улсын их хурлын гишүүнээр сонгогдох эрхтэй вэ?
- a. 30 нас
 - b. **25 нас**
 - c. 21 нас
 - d. 18 нас
51. Монгол улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг хэдэн жилийн хугацаагаар Монгол улсын ерөнхийлөгч томилдог вэ?

- a. **6 жил**
- b. 8 жил
- c. 2 жил
- d. 4 жил